

“ Э-ТРАНС ЛОЖИСТИКС “ ХК-НЫ 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- **Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг;**
Хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1-р баг 10-р хэсэг, Э-Транс Ложистикс ХК-ны байр
Утас: 02524543813, 99117636, 95956390
Электрон хаяг: www.etr.mn

- **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл;**

Компанийн нэр:	“ Э-транс Ложистикс “ ХК
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2011.12.06
Улсын бүртгэлийн дугаар:	0610001001
Регистрийн дугаар:	3309665
Үйл ажиллагааны чиглэл:	Ачаа шилжүүлэн ачих терминал
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	

- **Товч танилцуулга;**

Э-Транс ложистикс Хувьцаат компанийн хяналтын багцыг эзэмшигч Э-Транс Хязгаарлагдал хариуцлагатай компани нь 2007 оноос Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багийн нутагт төмөр зам дагасан байрлалд салбар зам барин ачаа шилжүүлэн ачих терминал байгуулах төсөл хэрэгжүүлснээр манай компанийн үйл ажиллагааны эхлэл тавигдсан гэж үздэг.

2007-2008 онд шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтыг хийж ашиглалтанд оруулсан бөгөөд 2009 оны 4 дүгээр сард анхны тээврийн хэрэгслээс вагонд шилжүүлэн ачих ажлыг хийж гүйцэтгэсэн.

2010 онд шилжүүлэн ачих терминалынхаа үйл ажиллагааг тусгаарлан Э-Транс ложистикс хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлсэн.

2012 оны 04 сард Монголын Хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн хувьцаат компани болсон ба 924 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татан техник тоног төхөөрөмж, барилга байгууламж, дэд бүтцээ сайжруулах, бүтээн босох ажлыг зохион байгуулсан.

2011-2015 оны хооронд тус компани нь ZOOMLION маркийн автокран, 5 тонны даацтай бага оврийн ус зөөвөрлөх машин, ачааг өргөж буулгаж зөөвөрлөх зориулалттай 2 ш погрузчик, боодлын ачааг шилжүүлэн ачих туузан дамжуурга бүхий төхөөрөмж, ажлын хэрэгцээнд Пулсар, Прусс, Старекс маркийн авто машинууд зэрэг техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт, гаалийн нэг цэгийн үйлчилгээ бүхий өөрийн оффисийн байр, 1500м² агуулах, уурын зуух барьж ашиглалтанд оруулсан зэрэг бүтээн байгуулалт хийсэн.

2011 онд Э-Транс ложистикс ХХК-нд үйл ажиллагаа нь шилжин ирсэнээс хойш нийт 24,064 вагон буюу 1,540,096 тонн ачааг шилжүүлэн ачиж харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн захиалгын дагуу түргэн шуурхай, найдвартай хүргүүлж ажилласан байна.

1.1. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

Тус компани нь 2016 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлд заагдсан 7 ажил үйлчилгээг 30 салбар ажлын хүрээнд тогтоосон хугацаанд хийхээр төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар хангалттай үзүүлэлттэй гарч байна. Гэхдээ тус компанийн үндсэн үйл ажиллагаа болох ачаа барааг шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа өмнөх оны мөн үеийнхээс 58,3%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь улс орны эдийн засгийн уналт, иргэд аж ахуйн нэгжийн худалдан авах чадварын бууралт, автозамаар ачаа тээвэрлэх явдал ихэссэн, төмөр замын ачаа тээврийн тариф өссөн зэрэг шалтгаануудаас болсон гэж үзэж байна.

Тус компани нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө зарим төрлийн ачаа барааг төмөр замаар тээвэрлэх боломж нөхцлийг судлах, тэдгээр ачаа барааг импортоор оруулж ирдэг иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөгч, захирал нартай хамтран ажиллах боломжийг судлах талаар тусгайлан оруулсан бөгөөд энэ ажлын хүрээнд “Жин Хун Руй” ХХК, “Эй Эм Жи Эм” ХХК, “Пирамид өргөө” ХХК, “АПУ” ХК, “Аз буяны цээл” ХХК, “Сэрвэн оргил” ХХК, “Сайхан хараа” ХХК, “Хаан сэлэнгэ” ХХК, “Алтан үрэл ингэт трейд” ХХК зэрэг компаниудын бие төлөөлөгчтэй уулзан хамтын ажиллагааны талаар санал солилцон зөвхөн өөрийн салбар замаар ачаа бараагаа тээвэрлүүлэх, тэдэнд ачилтын уян хатан нөхцөлийг олгох нөхцлийг санал болгосноор ачилтын асуудлыг харилцан тохиролцож чадсан.

Төмөр замаар тээвэр хийж байгаа тус компанийн хувьд үндсэн үйл ажиллагаа нь Улаанбаатар төмөр замын үйл ажиллагаанаас шууд хамааралтай байдаг тул төмөр замын бус ачаа тээврийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж нөхцлийг судлахын зэрэгцээ төмөр замын бусад ачаа тээвэр тухайлбал контейнер тээвэрлэх, хүнд даацын ачаа бараа тээвэрлэх зориулалт бүхий тоног төхөөрөмж байрлуулах нөхцөл, хөрөнгө оруулалтыг судлаж ажиллалаа.

Үндсэн үйл ажиллагаанаас гадна ажилчдын ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал, эрүү ахуйн аюулгүй байдлыг хамгаалах, ажилчдын өдөр тутмын ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой ажлуудыг үе шаттай зохион байгуулан компанийн дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн ослыг судлах байнгын комиссын бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журмыг ажилчдад танилцуулан, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх аюулыг мэдээлэх хуудас, түүнийг ашиглах журмыг боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдүүлэн ажиллаж байна.

Ажилчдыг зөвхөн ээлжийн хугацаанд үүрэг гүйцэтгэхэд анхаарахаас илүү өөрийн ажлын чиг үүргийн дагуух мэдлэгээ дээшлүүхэд анхаарч 2016 онд зохион байгуулагдах сургалтын хуваарийг гарган ажилчин бүр оногдсон 1-2 сэдвээр хичээл бэлтгэн бусад ажилчдадаа сургалт зохион байгуулж байгаа нь төмөр замын нарийн мэргэжлээр ажиллагсдын мэдлэгээ нэмэгдүүлэхэд нэмэр болсон ажил болж байна.

1.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;

Тус компанийн ажил үйлчилгээний гол хэлбэр нь ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэр дэх шилжүүлэн ачих бусад терминалуудаас дараах хүчин зүйлсээр давуу талтай байдаг.

1. Газар нутгийн байрлал: Компани нь БНХАУ-тай хиллэдэг улсын хилээс 5 км, худалдаа, аялал жуулчлалын чөлөөт бүс Эрээн хотоос 10 км, хилийн шалган нэвтрүүлэх 3-р цэгээс 100 метрийн зайд байрладаг.

2. Нэг дороос үйлчилгээ авах боломжтой: Тус компанийн гаалийн хяналтын бүсээр зарлагдан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гаалийн нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэн үйлчлүүлэгч нарын цаг, хөдөлмөрийг хэмнэж ирсэн. Мөн ачаа барааг шилжүүлэн ачих ачигч нарыг үйлчлүүлэгч нарт зуучилан түргэн шуурхай найдвартай шилжүүлэн ачих үйлчилгээг үзүүлдэг.

3. Техник тоног төхөөрөмжийн цогц үйлчилгээ: Үйлчлүүлэгч нарын хүсэл шаардлагад нийцүүлэн ачаа барааг шилжүүлэн ачих ажиллагаанд техник тоног төхөөрөмжийг ашигласнаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа түргэн шуурхай, элдэв гологдолгүй, бүрэн бүтэн захиалагч нарт хүргэгдэх нөхцөл бүрддэг.

4. Харуул хамгаалалтын найдвартай байдал: Тус компани 24 цагийн харуул хамгаалалтыг харуул хамгаалалтын алба хаагч нараар гүйцэтгүүлдэг бөгөөд харуул хамгаалалтын пост, төв оффисоос хяналтын IP камерын системээр гаалийн хяналтын бүс, ачилтын талбай, орж гарах үүд зэрэг бүх газрыг хянадаг.

5. Гаалийн баталгаат агуулах, хяналтын бүсийн цогц үйлчилгээ: Үйлчлүүлэгч нар нь өөрийн ачаа бараагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу гаалийн баталгаат агуулах, гаалийн хяналтын бүсэд төлбөртэйгөөр хадгалуулах боломжтой.

Доорх хүснэгтэд тус суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа бусад терминалын байдлыг харуулав.

Хүснэгт 1. Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж байгаа бусад терминалууд

Терминал	Хилийн хяналтын цэгээс терминал хүртэлх зай	Үйл ажиллагааны чиглэл	Онцлог
УБ Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 1	6 км	Нарийн болон өргөн царигын вагон хооронд хүнд даацын ачаа шилжүүлэн ачих болох хялбар муудах ачаа, чингэлгийг шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Хүнд даацын ачаа шилжүүлдэг
УБ Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 2	4 км	Нарийн царигаас өргөн царигын вагонд болон автомашинаас вагонд чингэлэг шилжүүлэн ачдаг.	2016 оны 07 дугаар сарын 1-нээс чингэлэг буулгахыг больсон.
УБ Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 3	11 км	Автомашинаас вагонд цемент шилжүүлэн ачдаг.	Барилгын материал болон өргөн хэрэглээний бараа шилжүүлэн ачдаг.

Улаанбаатар төмөр замын шилжүүлэн ачих цогцолборууд нь тус компанийн шилжүүлэн ачих цогцолбороос байрлалын хувьд хол, нийт ачааны дийлэнх ачааг шилжүүлдэг 1 болон 2-р шилжүүлэн ачих цогцолборуудад хүрч очих замын асуудал хүндрэлтэй / Замын-Үүд сумын дундуур явах шаардлагатай болдог / байдаг нь дээрх цогцолборуудаас давуу талтай болгож байдаг.

Гэхдээ вагон хангалтын хувьд Улаанбаатар төмөр замын Замын-Үүд өртөөнөөс шууд хамааралтай байдаг тул ачаа бараа байсан ч компанийн салбар замд вагон олгохгүй байх тохиолдол үүсдэг. Үүнийг Замын-Үүд өртөө болон тус компанийн хооронд байгуулсан


хамтын ажиллагаа болон салбар замын гэрээгээр ямар нэгэн асуудалгүй зохицуулан ажиллаж байна.

1.3. Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;

Хүснэгт 2. Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:

Сар	Цемент	Барилгын төрөл бүрийн материал	Кран	Модон материал	Бусад	Нийт
1.	16	33		10	54	113
2.	32	6	3	2	39	82
3.	130	48	2	10	5	195
4.	452	63	7	10	17	549
5.	602	66	10	9	12	699
6.	402	82	1	14	19	518
7.	299	45	5	7	20	376
8.	233	61	1	12	5	312
9.	47	45	1	5	8	106
10.	3	51	-	3	2	59
11.	-	35	-	2	4	41
12.	-	14	-	3	2	19
Нийт	2216	549	30	87	187	3069

График 1. 2015 оны мөн үеийг 2016 оны мөн үетэй харьцуулсан байдал



2016 оны эхний хагас жилд Улаанбаатар төмөр замаас харьяа шилжүүлэн ачих терминалууддаа үйлчлүүлэгч олж авах үүднээс өөрийн ачилтын тарифаа тодорхой хувиар

2 удаа багасгасан. Компанийн зүгээс үйлчлүүлэгчдээ алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мөн тодорхой хувиар ачилтын зардлыг буулгасан, найдвартай хамтран ажиллагч байгууллага, иргэдэд зориулсан бонустай үйлчилгээ хэрэгжүүлсэн, сэлгээ таталт тавилтыг аль болох түргэсгэсэн зэрэг үйлчлүүлэгчдээ дэмжсэн үйл ажиллагаа явуулсаны үр дүнд одоо тодорхой тооны найдвартай үйлчлүүлэгчтэй болсон гэж үзэж болно. Улс орны эдийн засгийн байдал, валютын өсөлт, худалдан авах чадвар буурсан зэрэг шалтгаануудын улмаас үйлчлүүлэгчидийн ачаа барааны эргэлт саарах, зогсох зэрэг таагүй нөхцөл байдал гарсан.


Барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд, хувь хүмүүсийн БНХАУ-аас худалдан авсан барилгын материалын дийлэнх хэсгийг цемент эзэлдэг бөгөөд 2015 онд тус компанийн шилжүүлэн ачилтын 80,4%-ийг цемент дангаар эзэлж байсан бөгөөд 2016 онд ачигдсан цемент өмнөх оны мөн үеийнхээс -62,6% буурсан нь нийт ачилтыг ихээхэн хувиар багасгасан.

Ингэж цемент болон барилгын материалын импорт багассан бас нэг шалтгаан бол дотоодын барилгын материал үйлдвэрлэгчдийг дэмжсэн бодлоготой холбоотойгоор импортын цементны гаалийн татвар, төмөр замаар тээвэрлэх ачилтын тариф нэмэгдсэнээс үүдэлтэй юм.

Хүснэгт 3. 2012-2016 онд ачигдсан вагоны тоо / сараар /

Сар	2012 он	2013 он	1014 он	2015 он	2016 он
1.	194	228	170	100	113
2.	116	95	70	76	82
3.	265	262	334	439	195
4.	303	403	301	955	549
5.	351	360	291	946	699
6.	442	463	301	921	518
7.	534	511	450	989	376
8.	649	329	652	1062	312
9.	600	358	451	946	106
10.	379	436	231	647	59
11.	305	319	132	154	41
12.	307	117	156	134	19
Дүн	4,445	3,881	3,539	7,369	3,069

График 2. 2012-2016 оны ачилт, буултын харьцуулсан үзүүлэлт / жилээр /



6122	5967	27827,3	43180,1	21	3	213479,2	82708,1
Өсөлт, бууралт				Өсөлт, бууралт			
-2,5%		35,5%		-85,7%		-61.2%	

2016 оны 1-р сараас техникийн паспортын эх хувьгүй автомашинуудыг гаалийн баталгаат агуулахаар дамжуулан бүрдүүлэлт хийж байхаар журамласантай холбоотойгоор нийт 1.762.620.23 ам.долларын статистик дүн бүхий 495 автомашин баталгаат агуулахад түр хадгалуулан гарсан.

Гаалийн хяналтын бүсэд 2016 оны байдлаар 5472 тээврийн хэрэгсэл нэвтэрч гаалийн бүрдүүлэлт хийгдэн гарахад үйлчилгээний хураамжийг хурааж авчээ. Үүнээс гадна баталгаат агуулахад түр хадгалагдахаар орж ирсэн дээрх 495 автомашинуудыг хяналтын бүсэд нэвтрүүлэн үйлчилгээ үзүүлсэний хураамжийг авснаар хяналтын бүсэд нэвтэрсний хураамж нийт 43180,09 төгрөгийг орлогод авсан нь өмнөх оныхоос 15352,8 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Баталгаат агуулахын орлого -61,2% болтлоо буурсан шалтгаан нь 2013 оноос хойш хадгалагдаж байсан Вагнер Ази, Линксровер, Мак ХХК-ийн хүнд машин механизмийн хадгалалтын хугацаа дуусч гарсан ба манай улсын уул уурхайн салбар зогсонго байдалтай байгаагаас 2016 онд дээрх компаниуд хүнд оврын машин механизм оруулж ирж удаан хугацаагаар хадгалуулаагүйтэй холбоотой юм.


1.5 Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан

Тус компани нь үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа буюу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь байгууллага, аж ахуйн нэгжийн дунд томоохонд орох татвар төлөгч аж ахуйн нэгж юм. 2011-2016 онд төлсөн татварын хэмжээг хүснэгтээс харвал:

Татварын төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үл хөдлөх хөрөнгийн орлогийн албан татвар	16,529,100	22,774,600	35,975,925	47,593,936	47,953,936	28,556,365
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	231,600	433,400	282,118	464,740	574,900	482,275
Газрын төлбөр	320,000	320,000	480,000	400,000	400,000	400,000
Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар	546,400	14,934,687	45,033,606	42,310,698	43,335,267	59,446,662
Хувь хүний орлогын албан татвар	3,326,846	9,678,791	13,892,548	16,472,167	20,397,566	22,411,896
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	12,580,300	12,362,365	11,066,987	23,065,456	27,623,094	122,285
Нийт дүн	33,534,246.00	60,503,843.00	106,731,184.00	130,306,997.00	140,284,763	111,419,483

Жич: Голлох татварын хэмжээг харуулав.

Үүнээс гадна нийгмийн даатгалын санд төлсөн даатгалын шимтгэлийг харвал:



2016 оны 02 дугаар сарын 05-д Дорноговь аймгий Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс “ Хэрэглэгчдийн итгэмжит шилдэгийн шилдэг хамт олон “-оор шалгаруулан өргөмжлөл хадгалуулсан.

1.6 Нийгмийн хариуцлагын тайлан

Байгууллагынхаа гадна, дотно тохижилтын ажлыг хамт олны хүчээр хийж “Ногоон байгууламж бидний орчин” гэсэн аяныг ажилчдын дунд өрнүүлэн Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04-р сарын 14-ны өдөр батлагдсан “ Мод тарих үндэсний өдөр зарлах тухай “ шийдвэрийн дагуу компанийн байрны 4 хэсэг газарт 800 ширхэг шар хуайс, хайлаас, голт бор, улиас тарьснаас одоо 500 ширхэг нь ургаж байна. Мөн наран цэцэг, ерхөг, согоовор зэрэг цэцэгт ургамлыг төв оффисийн хажууд тарьж ургуулсан нь энэ жилийн хамгийн сайхан байгууллагын өнгө үзэмжийг нэмсэн ажил болсон.

Замын-Үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвор суурьшил муу, шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоо ажлын тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл байдал доголдолтой байдаг нь ажилд сөргөөр нөлөөлдөг. Иймээс бид орон нутгийн харъяат иргэдээс залуу боловсон хүчнийг сургах, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэн компанидаа ажилуулах тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна. Одоогийн байдлаар тус компанийн ажилчдийн 23 нь буюу нийт ажилчдын 76,6%-ийг Зам-Үүд суманд оршин суудаг, сумын харъяат иргэд эзэлж байгаа бөгөөд үлдсэн 7 буюу 23,4%-ийг түр оршин суугч иргэд эзэлж байна.

Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр түлхүү анхаарч ажиллаж шаардлагатай зээл тусламж авахад дэмжлэг үзүүлэх, нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярыг хамт олон, гэр бүлээрээ тэмдэглэх, спортын болон хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.



Үүнээс гадна ажлын их ачаалал, ядралтыг тайлах зорилгоор жил бүр байгууллагынхаа ажилчдыг 3-7 хоног дотоод, гадаадын аялалыг зохион байгуулж байсан боловч энэ жил санхүүгийн хүндрэлээс болж энэ ажил хийгдээгүй байна.

2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2.1. Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.

2.2. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

Гүйцэтгэх удирдлага

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
3.	Хаваан Батхишиг	Менежер	Дээд, бизнесийн удирлага	2012 оноос хойш ажиллаж байна.
4.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Нямсүрэн Баярмаа	Касс-нярав	Дээд, нягтлан бодогч	2012 оноос хойш ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
3.	Санжмятавын Отгонбаяр	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий менежер
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Мэдээлэл аудит ХХК, мэргэжилтэн
5.	Баярсайханы Пүрэвбаатар	ТУЗ-ын гишүүн	Дээд	Говь караван ХХК, Санхүүгийн шинжээч
6.	Батсүхийн Мянганбаяр	ТУЗ-ын гишүүн	Дээд	Говь караван ХХК, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	Дээд	Оптималь проект ХХК, Захирал
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	Дээд	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал

2.3. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл

д/д	Овог нэр	Албан тушаал	Цалин урамшууллын хэмжээ	Эзэмшиж буй хувьцааны тоо
Төлөөлөн удирдах зөвлөл				
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	0₮	Эзэмшдэггүй
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	сарын 1.100.000	Эзэмшдэггүй
3.	Санжмятавын	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй

	Отгонбаяр			
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
5.	Баярсайханы Пүрэвбаатар	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
6.	Батсүхийн Мянганбаяр	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
Гүйцэтгэх удирдлага				
1.	Эрдэнэбаатарын Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
2.	Хавааны Батхишиг	Менежер	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
3.	Гомбын Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
4.	Нямсүрэнгийн Баярмаа	Касс-нярав	Сарын 700.000₮	Эзэмшдэггүй

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнээр ажиллаж байсан Б.Батбаатар нь 2016 оны 06 дугаар 24-ны өдөр гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн бөгөөд Монголиан Транспортэйшн Холдинг ХХК-ниас түр гишүүнд Б.Мянганбаярыг томилуулахаар нэр дэвшүүлэн ирүүлсэн ба энэ асуудлийг шийдвэрлүүлэхээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс саналын хуудсаар санал авч дийлэнх олонхийн саналаар Б.Мянганбаярыг түр гишүүнээр томилсон.

2.4. ТУЗ болон түүний дэргэдэх хороод

д/д	Овог нэр	Эзэмшсэн мэргэжил, боловсрол	Хараат бус гишүүн эсэх	ТУЗ-ын хороодод томилогдсон байдал
1.	Чулууны Энхболд	Ленинградын Төмөр замын дээд сургууль, Төмөр замын инженер	Энгийн	Нэр дэвшүүлэх хорооны дарга
2.	Чулууны Амарсанаа	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль, Уулын инженер	Энгийн	Аудитын хорооны гишүүн
3.	Санжмятавын Отгонбаяр	Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага	Энгийн	Цалин урамшууллын хорооны дарга
4.	Сэджавын Санжаа	Санхүү эдийн засгийн техникум	Хараат бус	Аудитын хорооны дарга, Цалин урамшууллын хорооны гишүүн
5.	Баярсайханы Пүрэвбаатар	University Tomas Bata in Zlin, Czech Republic, Business Administration	Энгийн	
6.	Батсүхийн Мянганбаяр	St.Benedicts Prep High School, USA, St.John's University, USA	Энгийн	
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ШУТИС, Нефтийн инженер	Энгийн	
8.	Ариунболдын Батболд	Санкт-Петербургийн төмөр замын дээд сургууль, төмөр	Хараат бус	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, цалин

		замын инженер, бизнесийн удирдлагын магистр		урамшууллын хорооны гишүүн
9.	Халтарын Батхишиг	ШУТИС, Нефтийн инженер	Хараат бус	Аудитын хорооны гишүүн, нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Компани нь 2016 оны 04 дүгээр сарын 15-нд “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгосон бөгөөд 2016 оны 05 дугаар сарын 09-ны өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 007^Б тоот тогтоолоор баталгаажуулсан.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороог С.Санжаа, Х.Батхишиг, Ч.Амарсанаа гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулан Аудитын хорооны даргаар ТУЗ-ын хараат бус С.Санжаа гишүүнийг томилсон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороог С.Отгонбаяр, С.Санжаа, А.Батболд гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулан Цалин, урамшууллын хороог С.Отгонбаяр гишүүнийг томилсон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороог Ч.Энхболд, Х.Батхишиг, А.Батболд гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулан Нэр дэвшүүлэх хорооны даргаар Ч.Энхболдыг томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр 2-3 удаа хуралдаж тодорхой асуудлуудыг шийдвэрлэсэн.

2.5. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

Компанийн гүйцэтгэх удирдлагаас эдийн засгийн хүндрэл, гадаад валютийн өсөлт, төгрөгийн ханшний сулралт, иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авах чадварын бууралт зэрэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд асар их хүндрэл учруулах нөхцөл байдлуудыг өөрийн нөөц бололцоогоороо амжилттай даван туулж байна.

Гүйцэтгэх удирдлагаас төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдтэй уялдаа холбоотой, нягт хамтран ажилласны дүнд Хас банкинд дахь 99.800 долларын зээлийг төгрөгийн зээлд шилжүүлэх шаардлагын үүднээс Худалдаа хөгжлийн банкнаас 3 жилийн хугацаатай сарын 1,8%-ийн 200,000,000 сая төгрөгний зээл авч валютын зээлээ төлж барагдуулсан. Энэ нь тухайн үед ам.долларын өсөлтөөс шалтгаалан ханшийн зөрүүний алдагдал их үүсч төлөлтийн явцад их алдагдал хүлээх байсан, цаашид ч ам.долларын ханш нь өсөх магадлалтай байдлыг урьдчилан харж асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар оруулан шийдвэрлэсэн маш чухал ажил болсон.

Мөн Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь гаалийн байгууллагатай хамтран экспортоор гарч байгаа бүх төрлийн ачааг тус компанийн баталгаажсан автопүүн дээр пүүлэн жин, тонныг баталгаажуулан улсын хилээр гаргах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажилд орууллаа Ингэснээр төмөр замаар тээвэрлэгдэж байгаа экспортын ачаа буурч байгаа үед буултнаас олох орлогын тодорхой хувийг дээрх төрлийн үйлчилгээнээс нөхөх боломжтой болсон.

Гүйцэтгэх удирдлага нь компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог хангах үүднээс Улаанбаатар төмөр зам, Гаалийн ерөнхий газар, Хилийн цэргийн ерөнхий газар болон аймаг орон нутгийн нутгийн захиргааны байгууллагууд,

харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудтай тогтмол харилцаатай байгаа бөгөөд 2017 онд зарим үйл ажиллагааг шинээр болон үргэлжлүүлэн хийхээр төлөвлөн ажиллаж байна.

2.6. “ Компанийн засаглалын кодекс “-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан

Тус компани нь “ Компанийн засаглалын кодекс “-ийг мөрдөн дагаж ажиллаж байгаа бөгөөд өөрийн компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээ компанийн өөрийн веб сайт / одоо засвартай байгаа /, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж, Монголын Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн веб сайтуудад тавьж олон нийт болон хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж байгаа болно.

3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

3.1. Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;

НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн дансуудыг ангилан, туслах дансуудыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан коджуулан хэрэглэж байгаа бөгөөд дансны жагсаалт нь баланс болон орлого, үр дүнгийн тайлангуудын дансуудаас бүрддэг. Санхүүгийн жилийн татвар ногдох орлого, зардлаа Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккруэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор баталгаажуулан Төрийн сан болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг. Мөн бид санхүүгийн тайлангаа өөрийн веб сайтандаа байршуулдаг ба энэ нь манай дотоодын харилцагч нараас гадна дэлхийн аль ч улс орноос харилцагчид санхүүгийн мэдээллийг бодитой, шуурхай авах боломжийг олгодог.

Санхүүгийн байдал

Үзүүлэлт	2015	2016	Өсөлт бууралт
Эргэлтийн хөрөнгө	188,220.68	98,006.81	-48%
Эргэлтийн бус хөрөнгө	6,018,304.57	5,755,839.59	-4%
Нийт хөрөнгийн дүн	6,206,525.24	5,853,846.40	-6%
Өр төлбөр	317,919.80	278,398.32	-12%
Эздийн өмч	5,888,605.45	5,575,448.08	-5%
Нийт өр төлбөр, эздийн өмчийн дүн	6,206,525.24	5,853,846.40	-6%

Нийт хөрөнгө 6%-иар буурсан үзүүлэлттэй байна. Нийт өр төлбөрийн дүн 12%-иар буурсан нь зээлийн үндсэн төлөлт хийсэнтэй холбоотой ба эздийн өмчийн хэсэг бүүрсан нь хуримтлагдсан ашгийн бууралтаас үүссэн байна.

Орлого үр дүн		
Үзүүлэлт	2015	2016
Борлуулалтын орлого (цэвэр)	8,444,062.10	553,480.60
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг (Үйлчилгээний өртөг)	8,036,508.00	0.00
Нийт ашиг (алдагдал)	407,554.10	553,480.60
Түрээсийн орлого	45,927.30	32,318.30
Хүүний орлого	2,419.80	1,222.80
Бусад орлого	70,818.80	61,517.40
Ерөнхий ба удирдлагын зардал	347,760.20	911,424.40
Санхүүгийн зардал	48,339.80	32,130.90
Бусад зардал	0.00	0.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(17,213.60)	592.10
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(331.60)	0.00
Бусад зардал	(36,289.30)	(18,611.00)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	76,785.50	(313,035.10)
Орлогын татварын зардал	15,141.60	1,184.30
Татварын дараах ашиг (алдагдал)	6,643.90	(314,219.40)

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН ОРЛОГЫН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Тодруулга	2015	2016
			млн.төг	млн.төг
1	Тээвэр зуучийн орлого	3	8,444,062.1	553,480.6
2	Үзүүлсэн үйлчилгээний өртөг		8,036,508.0	-
3	Нийт ашиг		407,554.1	553,480.6
4	Түрээсийн орлого		45,927.3	32,318.3
5	Хүүний орлого	4	2,419.8	1,222.8
6	Бусад орлого		70,818.8	61,517.4
7	Удирдлагын зардал		347,760.2	911,424.4
8	Санхүүгийн зардал	5	48,339.8	32,130.9
10	Гадаад валютын ханшны зөрүүний олз		(17,213.6)	592.1
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		(331.6)	-
12	Бусад зардал	6	(36,289.3)	(18,611.0)
13	Татвар төлөхийн өмнөх ашиг		76,785.5	(313,035.1)
14	Орлогын татварын зардал	7	15,141.6	1,184.3
15	Тайланг үеийн цэвэр ашиг		61,643.9	(314,219.4)
16	Нэгж энгийн хувьцаанд ногдох ашиг, төгрөгөөр	8	1.33	(6.80)

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН
БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тод - руулга	2015.12.31 млн.төг	2016.12.31 млн.төг
ХӨРӨНГӨ			
<u>Эргэлтийн Хөрөнгө</u>			
Мөнгөн хөрөнгө	9	90,755.0	4,597.7
Дансны авлага	10	23,716.2	1,265.0
Бусад авлага		3,692.3	0.5
Хангамжийн материал	11	70,057.2	92,143.6
Эргэлтийн хөрөнгийн дүн		188,220.7	98,006.8
<u>Эргэлтийн бус хөрөнгө</u>			
Үндсэн хөрөнгө	12	6,029,057.8	6,041,497.4
Хуримтлагдсан элэгдэл		(857,172.9)	(1,060,569.9)
Биет бус хөрөнгө	13	845,357.5	773,850.0
Хойшлогдсон татварын хөрөнгө		1,062.0	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		6,018,304.4	5,754,777.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		6,206,525.1	5,852,784.3
<u>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР</u>			
<u>Богино хугацаат өр төлбөр</u>			
Дансны өглөг	14	117,205.7	104,167.6
Орлогын татварын өглөг		1,352.7	24,771.7
Банкны богино хугацаат зээл		199,361.3	
Урьдчилж орсон орлого			
Богино хугацаат өр төлбөрийн дүн		317,919.7	128,939.3
<u>Урт хугацаат өр төлбөр</u>			
Урт хугацаат зээл	15	-	149,459.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	149,459.0
Өр төлбөрийн нийт дүн		317,919.7	278,398.3
<u>Эздийн өмч</u>			
Энгийн хувьцаа	16	4,620,000.0	4,620,000.0
Нэмж төлөгдсөн капитал		154,000.0	154,000.0
Хуримтлагдсан ашиг	17	339,747.4	25,528.0
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг			
		774,858.0	774,858.0
Эздийн өмчийн дүн		5,888,605.4	5,574,386.0
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР		6,206,525.1	5,852,784.3

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Эдийн өмчийн бусад хэсэг	Нийг дүн
	(мян.төг)	(мян.төг)	(мян.төг)	(мян.төг)	(мян.төг)
2014.12.31 нээрх үлдэгдэл					
Эзний нэмж оруулсан хөрөнгө					
Бусад дэлгэрэнгүй орлого					
Ногдол ашиг					
2014 оны татварын дараах ашиг					
2015.12.31 нээрх үлдэгдэл	4,620,000.0	154,000.0	339,747.4	774,858.0	5,888,605.4
Эзний нэмж оруулсан хөрөнгө					
Хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
Ногдол ашиг					
2016 оны татварын дараах алдагдал			(314,219.4)		(314,219.4)
2016.12.31 нээрх үлдэгдэл	4,620,000.0	154,000.0	25,528.0	774,858.0	5,574,386.0

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,626,441.4	731,570.1
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,603,649.8	725,137.5
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан	3,248.0	3,925.0
	Бусад мөнгөн орлого	19,543.6	2,507.6
1.2	Мөнгөн зарлага (-)	8,275,287.5	747,413.7
	Ажиллагчдад төлсөн	250,892.6	207,747.5
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	27,682.0	47,470.2
	Бараа материал худалдан авахад төлсөн	387,970.8	171,888.3
	Ашиглалтын зардалд төлсөн	65,571.8	67,813.2
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,334,117.9	74,509.6
	Хүүний төлбөрт төлсөн	35,460.2	32,130.9
	Татварын байгууллагад төлсөн	124,103.3	74,046.1
	Даатгалын төлбөрт төлсөн	476.4	742.7
	Бусад мөнгөн зарлага	49,012.5	71,065.2
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	351,153.9	(15,843.6)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,419.8	10,584.6
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,000.0	
	Хүлээн авсан хүүний орлого	2,419.8	1,222.8
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа		9,361.8
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		(10,000.0)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		10,000.0
2.3	гүйлгээний дүн	6,419.8	584.6
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	25,870.0	
	Зээл авсан, өрийн үнэг цаас гаргаснаас хүлээн авсан	25,870.0	215,000.0
	Хувьцаа болон өмчийн бусад үнэг цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	313,900.4	
	Зээл, өрийн үнэг цаасны төлбөрт төлсөн мөнгө	313,900.4	(285,898.2)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	(288,030.4)	(70,898.2)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	69,543.3	(86,157.3)
5	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,211.7	90,755.0
6	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	90,755.0	4,597.7

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

2017 оны 2 сарын 10 өдөр

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК –ийн хувьцаа эзэмшигчдэд

Бид танай байгууллагын 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Зорчилгүй дүгнэлт

Танай байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв.

Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн “Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага” хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм.

Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв. Аудит хийхдээ аудитын горим (Шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгах гэх мэт)-уудыг ашиглав.

Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

Тайлангийн зориулалт

Энэхүү тайланг танай байгууллагын хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиталсан санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.



Handwritten signature of T. Sugarsuren

Т.СУГАРСҮРЭН

Компанийн үндсэн үйл ажиллагааны орлого нь ачаа тээврийн зуучлалын үйлчилгээний орлого юм. Өмнөх санхүүгийн тайлангуудад үйлчлүүлэгчдээс хүлээн авсан мөнгийг орлогоор, төмөр замд төлсөн тээврийн хөлсийг зардал (үзүүлсэн үйлчилгээний өртөг)-аар бүртгэж зөрүүгээр нь нийт ашгийг тодорхойлж байсан бол 2015 оны 10 сарын 1-ээс энэхүү төмөр замын тээврийн хөлсийг хассан цэвэр дүнг орлого гэж бүртгэх болсон. Нягтлан бодох бүртгэлийн энэхүү бодлогыг цаашид ч тууштай мөрдөх юм.

3.2. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

3.3. Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл

Худалдаа хөгжлийн банкнаас 3 жилийн хугацаатай сарын 1,8%-ийн 200,000,000 сая төгрөгний зээл авч Хас банкинд дахь 99800 долларын зээлийг хаасан. Ам.долларын өсөлтөөс шалтгаалан ханшийн зөрүүний алдагдал их үүсч төлөлтийн явцад их алдагдалтай байдаг байсан бөгөөд ам.долларын ханшийн өсөлт бууралтын ирээдүйн байдал цаашид ч мөн өсөх нөхцөл байдалтай байсан тул ТУЗ-ын гишүүдийн саналыг авч ТУЗ-ын шийдвэрийг үндэслэн зээл авсан. Зээлийн эргэн төлөлтийг гаргахдаа үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан хэрхэн зээлийн эргэн төлөлтийг хийж байхаар зээлийн хуваарийг гаргасан. Зээлийн барьцаа хөрөнгөнд нэг цэгийн үйлчилгээний барилгыг барьцаалсан.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016.04.15-ны өдөр нийт хувьцааны 92.55% буюу 42,759,098 ширхэг хувьцаа эзэмшиж буй 11 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй хуралдсан. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт орсноор Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулах тухай заалт нэмж оруулахыг хувьцаа эзэмшигчдийн 99.9994% нь зөвшөөрсөн, 0.0006% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан.
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.
- Компанийн аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсвийг батлах тухай асуудлаар хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.

- Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн 99.9994% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн 0.0006% нь татгалзсан байна.
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүдээр Ч.Энхболд, Б.Пүрэвбаатар, Б.Батбаатар, С.Отгонбаяр, Ч.Амарсанаа, Б.Лхагвадорж нар, хараат бус гишүүдээр С.Санжаа, А.Батболд, Х.Батхишиг нар сонгогдсон.

4.2. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;

д/д	Овог нэр / хуулийн этгээдийн нэр /	Албан тушаал	Хувьцааны хувь
1.	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2.	Би Ди Сек ХК	Брокер дилер, андеррайтэрийн компани	31.43%
3.	Монголиан Транспортэйшн Холдинг ХХК	Хөрөнгө оруулалтын сан, Люксембургийн вант улс	11.08%

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болох Чулууны Энхболд, гишүүн Санжмятавын Отгонбаяр, Баярсайханы Пүрэвбаатар, Батсүхийн Мянганбаяр, Бүрэнмэндийн Лхагвадорж болон гүйцэтгэх захирал Чулууны Амарсанаа нар нь компанийн хараат гишүүд болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болох Ариунболдын Батболд, Халтарын Батхишиг, Сэджавын Санжаа нар нь компанийн хараат бус гишүүд болно.

4.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн мэдээлэл;

Компани нь Э-Транс ХХК, Монголиан Транспортэйшн Холдинг ХХК, БиДиСек ҮЦК ХК гэсэн 5%-иас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд 2016 онд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсэд өөрчлөлт ороогүй болно.

4.4. Компанийн эрх бүхий ажилтан болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бусад компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл;

5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5.1. Компанийн тухайн жилийн ногдол ашгийн тухай;

Компани нь 2016 онд эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан алдагдалтай ажилласан учраас ногдол ашиг олгохгүйгээр 2017 оны 02 дугаар сарын 13-нд хуралдсан ТУЗ-ын хурлаар шийдвэрлэсэн.